



БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЧЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ

1990 оны 1

сарын 04 өдөр

дугаар 01

Улаанбаатар

Изээлж 1993 онох А/262 дэгчилж аар хот
хүчинчилж.

Хотын тохиижилт чимэглэлийн зураг төслийн товчоо байгуулах, хотын тохиижилтийн ажлыг чанартай зураг төслеэр хангах, санхүүжилтийн ажлыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай

БНМАУ-ны Сайд нарын Зөвлөлийн 1983 оны 29, 1989 оны 152 дугаар тогтоолыг үндэслэн Ардын хувьсгалын 70 жилийн ойг угтаж хотын тохиижилтийн ажлыг чанартай зураг төслеэр хангах, санхүүжилтийн ажлыг боловсронгуй болгох зорилгоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын тохиижилт, чимэглэлийн талаар нэгдсэн бодлого явуулах, хотын нийтийн эзэмшлийн бус, орон сууц, гэрийн хорооллын тохиижилтийн нарийвчилсан ерөнхий төлөвлөгөө, архитектурны жижиг байгууламж, усан оргилуур, монументаль болон уран сайхны чимэглэлийн эскиз, тохиижилтийн ажлын зураг тесэв боловсруулах, барилгын гадна талын засал чимэглэл, өнгийг паспортжуулах ажлыг эрхлэн гүйцэтгэх хотын тохиижилт чимэглэлийн зураг төсвийн товчоог 1990 оноос эхлэн Архитектур төлөвлөлтийн газарт байгуулж ажиллуулсугай.

2. Хотын тохиижилт, чимэглэлийн зураг төсвийн товчооны орон тоо, цалингийн фондыг зохих журмын дагуу баталж өгөхийг хотын санхүүгийн халтэс /н.Гонгор/-т даалгасугай.

3. 1990 онд хийх тохиижилт, гэрэлтүүлэг, рекламын ажлын зураг төсвийг 1990 оны нэгдүгээр улиралд, цаашид дараа оныхыг урд оны Ш сард багтаан боловсруулж байхыг Архитектур төлөвлөлтийн газар /н.Жадамбаа/-т даалгасугай.

4. Хотын тохиижилт, цэцэрлэгжүүлэлт, реклам чимэглэлийн хэтийн төлөвийг хотын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тодорхой үе шатанд хэрэгжүүлэхээр райончлон боловсруулж, эхийн ээлжинд

2.

тохижуулах объектуудыг эскиз, макет, төслийн даалгаврын үе шатаар жил бурийн нэгдүгээр сард хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны хурлаар оруулан хот тохижилтын дараа оны төлөвлөгөөний төсөл болгон батлуулж байхыг Төлөвлөгөө, эдийн засгийн халтэс /н.Бат/, Архитектур төлөвлөлтийн газар /н.Жадамбаа/, Хот тохижуулах газар /н.Эрдэнэ-Очир/, Ажилчин, Багануур, Найрамдал, Налайх, Сүхбаатар, Октябрьин районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /нн.Ойцовсамбуу, Дацдаваа, Магсаржав, Канцан, Жавзмаа, Мандах/-нд даалгасугай.

5. Районы нутаг дэвсгэрийн тохижилтын хэтийн төлөвийг тодорхойлсон нацсан өрөнхий төлөвлөгөө, районы хүчээр нийтийн эзэмшилийн бусад тохижуулах объект /Хот тохижуулах газрын хариуцахаас бусад/ байгууллагуудын орчны тохижилт, барилгын гадна талын засал чимэглэл, өнгө будгийн паспортжуулалт гэрийн хорооллын тохижилтыг тухайн районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа, хотын нийтийн эзэмшилийн бус, гэрэлтуулаг рекламынхыг Хот тохижуулах газар, орон сууцны хорооллынхыг ОСНААУ газар тус тус хариуцан тэдгээрээс дараа онд гүйцэтгэх объектуудын зураг төсвийг жил бурийн хөёргүүдээр сард багтаан Архитектур төлөвлөлтийн газарт захиалж байхыг Ажилчин, Багануур, Найрамдал, Налайх, Сүхбаатар, Октябрьин районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /нн.Ойцовсамбуу, Дацдаваа, Магсаржав, Канцан, Жавзмаа, Мандах/, Хот тохижуулах газар /н.Эрдэнэ-Очир/, Орон сууц, нийтийн аж ахуйг удирдах газар /н.Баасанжав/-т дэвсгэрийн байгууллагуудын дарга эрхлэгч нарт даалгасугай.

6. Хотын тохижилтын нарийвчилсан өрөнхий төлөвлөгөө, реклам чимэглэлийн эскиз, архитектурын жижиг байгууламжийн альбом каталог боловсруулахад зориулж жил бур 300,0 мянган төгрөгийг Хот тохижуулах газарт улсын төсвийн хөрөнгөнөөс хуваарилан олгож байхыг Хотын санхүүгийн халтэс /н.Гонгор/-т, байгууллагуудын орчны тохижилт, барилгын өнгө будгийн паспортжуулалтын зураг төсвийн үнийг тухайн байгууллагуудын зардаар гүйцэтгэж байхыг Архитектур төлөвлөлтийн газар /н.Жадамбаа/-т даалгасугай.

7. Хотын гудамж талбайн нийтийн эзэмшилийн эд аж ахуй, ногон байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээний ажил тохижил-

3.

тын жижуурдийн төлөвлөгөө хөтөлж явуулахад зориулан хотын I:500, I:2000, I:5000-ны масштабтай дэвсгэр зураг тус бүр хоёр хувийг олшируулж Хот тохижуулах газарт олгохыг Архитектур төлөвлөлтийн газар /н.Жадамбаа/, газрын зургуудыг тогтоосон журмын дагуу хэргэлэхийг Хот тохижуулах газар /н.Эрдэнэ-Очир/-т даалгасугай.

9. Хотын нийтийн эзэмшийн бусийн тохижилт, гэрэлтүүлэг, рекламын захиалагчийн уургийг Хот тохижуулах газар хариуцах. болсонтой холбогдуулж захиалагч инженерийг ажиллуулан техник хяналтын зардлаас цалинжуулахыг Барилга захиалагчийн товчоо /н.Гомбосурэн/, Хот тохижуулах газар /н.Эрдэнэ-Очир/-т зөвшөөрсүгэй.

10. Тохижилт, рекламын зураг төсвийн унийг хот тохижуулах арга хэмжээний зардлаас урьдчилан төлж, санхүүжилт хийгдсэний дараа хөрөнгө оруулалтаас нөхөн авч байхыг Хот тохижуулах газар /н.Эрдэнэ-Очир/-т даалгасугай.

II. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хот чимэглэл зураг төслийн труши байгуулах тухай" Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргыны 1984 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 29 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

С.МОНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЧ-
ДАРГАИ НАРИИН БИЧТИЙН ДАРГА

Д.АЛГИА